



СОЁМБО

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№236 /445/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.12.29

Цаг үе, үйл явдал

БАТЛАН ХАМГААЛАХ САЙДЫН ДЭРГЭДЭХ “ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛ” ХУРАЛДЛАА

Өнөөдөр Батлан хамгаалахын сайдын дэргэдэх Иргэний зөвлөлөөс 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажил арга хэмжээгээ тайлагнахын зэрэгцээ санал бодлоо солилцож, цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны бодлого, зорилтоо тодотголоо.

Эл хуралд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, Батлан хамгаалахын сайдын зөвлөх чөлөөнд байгаа дэслэгч генерал Ц.Дашзэвэг, Иргэний зөвлөлийн дарга, гишүүд оролцлоо.

Хурлыг нээж Батлан хамгаалахын сайдын зөвлөх чөлөөнд байгаа дэслэгч генерал Ц.Дашзэвэг Батлан хамгаалахын сайдын дэргэдэх “Иргэний зөвлөл”-өөс хийж хэрэгжүүлсэн арга хэмжээг нийт бие бүрэлдэхүүнд тайлагнасан юм.

Үргэлжлүүлэн Батлан хамгаалахын



сайд Г.Сайханбаяр “Иргэний зөвлөл”-ийн гишүүдийн санал хүсэлтийг сонсож, харилцан мэдээлэл солилцлоо.

Энэ үеэр Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр хэлсэн үгэндээ, “Батлан хамгаалах яам АТГ-ын 2022 оны “Шударга байдлын үнэлгээ”-гээр Засгийн газрын бусад яамдыг тэргүүлж, бүх төрийн байгууллагуудаас тавдугаар байрт шалгарсан нь өмнөх оноос 46 байр


урагшилсан амжилт боллоо. 2022 он бид бүхний хувьд амжилт бүтээлээр дүүрэн, ажил үйлсийн арвин ундаргатай жил байлаа. Батлан хамгаалахын сайдын дэргэдэх “Иргэний зөвлөл”-ийн хувьд 2022 онд Зэвсэгт хүчний үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл хүмүүжлийг төлөвшүүлэх, хугацаат цэргийн алба хаагчдын ар гэртэй цэргийн

нэгтгэл, ангийн удирдлагыг холбох, хамтын ажиллагааг бэхжүүлэх үүргээ маш сайн гүйцэтгээнд чин сэтгэлийн талархал илэрхийлье” гэсэн юм.

Эл зөвлөл нь 2022 оны 11 дүгээр сарын 2-ноос 12 дугаар сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаанд Зэвсэгт хүчний дугаар ангиудын удирдах албан тушаалтан, ажилтан албан хаагч, гэрээт болон хугацаат цэргийн нийт 2203 алба хаагчид батлан хамгаалах бодлого, хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээг сурталчлах, тэдний сэтгэл зүй, ёс суртахуун, харилцаа хандлага, төлөвшил, хувь хүний хөгжил, манлайлал, цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн боловсрол олгох зорилготой 88 багц цагийн соён гэгээрүүлэх сургалтыг зохион байгуулсан зэргээр олон ажил, арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэн ажиллажээ.



ШАГНАЛЫН ХҮР БУУЛАА



Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 111 жилийн ойг тохиолдуулан эрхэлсэн ажил, салбартаа олон жил үр бүтээлтэй ажиллаж, онцгой амжилт гарган Батлан хамгаалах, Зэвсэгт хүчнийг хөгжүүлэн бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж буй офицер, ахлагч, ажилтан албан хаагчдад төрийн одон, медаль гардуулах ёслолын ажиллагаа өнөөдөр Офицеруудын ордонд боллоо.

Шагналыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, ЗХЖШ-ын дарга бригадын генерал

С.Ганбямба нар гардуулав. Тодруулбал, Монгол Улсын Гавьяат эдийн засагч цолоор БХЯ-ны Санхүүгийн хэлтсийн дарга асан, ахмад ажилтан, чөлөөнд байгаа хурандаа Ц.Ишдорж, Цэргийн гавьяаны Улаан тугийн одонгоор ЗХЖШ-ын ахлагч, тэргүүн ахлагч Н.Баасан, Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн захирагч хурандаа Ч.Эрдэнболд, БХЯ-ны Ахмадын хорооны гишүүн, ахмад ажилтан, чөлөөнд байгаа ахлагч Ж.Норовсүрэн нарын зургаан хүн, Цэргийн гавьяаны одонгоор ҮБХИС-ийн Аюулгүй байдлын дээд сургуулийн захирал хурандаа Э.Нацагдорж, “Багабаян-Энхийн төлөө” цогцолбор төв ТӨААТҮГ-ын жолооч, засварчин, чөлөөнд байгаа хошууч М.Пүрэвдорж, Монгол цэргийн музейн лабораторийн эрхлэгч-археологич, бэлтгэл дэд хурандаа Л.Гантөмөр нарын 14 хүн,

“Алтан гадас одон”-гоор ҮБХИС-ийн Ар талын хэлтсийн Хангалт үйлчилгээний албаны дулааны төвийн механикч Б.Чимэдцэрэн, ҮБХИС-ийн Санхүүгийн хэлтсийн тооцооны нягтлан бодогч О.Оюунгэрэл, “Соёмбо” редакцын сонин эх бэлтгэгч нярав Г.Алтанцэцэг нарын 20 хүн, “Цэргийн хүндэт медаль”-иар ҮБХИС-ийн Цэргийн нэгдсэн дээд сургуулийн Цэргийн ар талын тэнхимийн багш дэд хурандаа Т.Нямсамдан, ЗХЖШ-ын Материал, техникийн газрын Техникийн хэлтсийн ерөнхий инженер, техникийн хангалт, нөөцийн төлөвлөлтийн ахлах мэргэжилтэн дэд хурандаа Ж.Эрдэнэсайхан, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Санхүүгийн хэлтсийн дарга дэд хурандаа М.Отгонпүрэв нарын 12 хүн, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар БХЯ, ЗХЖШ-ын Үйлчилгээ, аж ахуйн хэлтсийн жолооч П.Хүрэлбаатар, ҮБХИС-ийн Цэргийн хөгжмийн коллежийн ерөнхий эрдмийн тэнхимийн багш Х.Мөнхтариа, ҮБХИС-ийн Ар талын хэлтсийн талхан цехийн эрхлэгч Н.Эрдэнэчимэг нарын есөн хүн шагнагдсан юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Гавьяат цол хүртсэн болон Төрийн дээд одон, медаль хүртсэн та бүхэндээ халуун баяр хүргэе. Энэ онд Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний бодлого зорилт хангагдсан, бодлогын шинэчлэл хийгдсэн, шинэ төрлийн цэргийн командлалуудын үйл ажиллагааг жигдрүүлсэн, батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргасан, Зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийн шинэчлэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн, энхийг дэмжих ажиллагаа, улс орныхоо стратегийн бүтээн байгуулалтын болон бусад ажилд манлайлан оролцсон, алба хаагчдынхаа ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулсан, цэргийн ёслол хүндэтгэлийн түүхэн арга хэмжээг зохион байгуулсан зэрэг олон арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсэн, ололт амжилтаар дүүрэн жил байлаа. Айлчлан ирж буй 2023 он Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Батлан хамгаалах, Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх стратегийн төлөвлөлтийн баримт бичгүүдийн хэрэгжилтийг бүрэн хангасан, Зэвсэгт хүчний хэмжээнд үйл ажиллагааны бүхий л талын хөгжил шинэчлэлийн жил байх болно” хэмээн онцолсон юм. Дэслэгч Т.ИДЭР

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-14	-26

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
35	22

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.465	3.475
EUR	3.695	3.715
CNY	494	497
RUB	47.20	48.50
JPY	26.00	26.20
KRW	2.71	2.73

ЗУРХАЙ

2022.12.30 / БААСАН ГАРАГ / БИЛГИЙН ТООЛЛЫН 6

ӨВЛИЙН ДУНД ХАР ХУЛГАНА САР НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ УЛААГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:
Нас уртасна
Наран ургах, шингэх:
08.42-17.07
Барилдлага:
Идэр
Шүтэн барилдлага:
Хүрэлцэхүй

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд зөрөг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Эл өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, хараал дарах, гал мандал хий зэрэгт сайн. Баруун нүд татвал эд олох, баруун чих хангинавал аймшиг болох, зүүн чих жингэнэвэл жуулчин ирэх, хэрээ дуугарвал зочин ирэх, тагнай загатанал амгалан болох, бие татвал эцэг эх цочих, хөл татвал тэмцэл болно.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 664,154,481
Эдгэрсэн Нийт: 636,124,782
Нас барсан Нийт: 6,694,274

Цаг үе, үйл явдал

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ШИЛДГҮҮД ШАЛГАРЛАА



Энэ онд Зэвсэгт хүчний өмнө дэвшүүлсэн зорилго, зорилтуудыг бүрэн хангаж, ажил үйлс, бүтээлч үйл ажиллагаагаараа бусдыгаа манлайлсан тэргүүний анги, салбар болон Зэвсэгт хүчний Жанжин штабын 2022 оны тэргүүний зохион байгуулалтын бүтцийн нэгж, алба хаагчдыг тодруулан,

Х.Аскербек захирагчтай Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 103 дугаар тусгай салбар, "Зэвсэгт хүчний оны тэргүүний офицер"-оор Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн Программ хангамжийн төвийн системийн инженер ахлах дэслэгч Д.Давааням, "Зэвсэгт хүчний оны тэргүүний ахлагч"-аар Зэвсэгт

ангийн Барилгын материал үйлдвэрлэлийн ротын бетон хийцийн тасгийн блокчин, гэрээт цэргийн алба хаагч байлдагч Ш.Эрдэнэ-Очир нар шалгарлаа. Мөн "Зэвсэгт хүчний Жанжин штабын оны тэргүүний зохион байгуулалтын бүтцийн нэгж"-ээр хурандаа Н.Лхагвасүрэн даргатай Цэргийн албаны хэлтэс, "ЗХЖШ-ын оны тэргүүний удирдах албан тушаалтан"-аар Хэвлэл мэдээллийн албаны дарга хурандаа Б.Отгонбаяр, "ЗХЖШ-ын оны тэргүүний ахлах мэргэжилтэн"-ээр Материал, техникийн газрын Зэвсгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн хошууч Б.Энхмагнай, "ЗХЖШ-ын оны тэргүүний мэргэжилтэн"-ээр Цэргийн хамтын ажиллагааны хэлтсийн Олон улсын гэрээ, эрх зүйн мэргэжилтэн хошууч Б.Золжаргал, "ЗХЖШ-ын оны тэргүүний туслах мэргэжилтэн"-ээр Материал, техникийн газрын Зэвсгийн хэлтсийн зэвсэг, галт хэрэглэлийн тоо бүртгэл хариуцсан туслах мэргэжилтэн ахлагч М.Цогтгэрэл, "ЗХЖШ-ын оны тэргүүний ажилтан албан хаагч"-аар Захиргааны удирдлагын хэлтсийн эрхлэгч, архивч Ө.Тунгалаг-Өлзий нар шалгарч, хамт олноо хошуучлав.



үйл ажиллагаандаа бодит үнэлэлт, дүгнэлтийг өгсөн юм.

Ирэх онд Зэвсэгт хүчний өмнө дэвшүүлсэн зорилго, зорилтуудыг хангахад Та бүхний үүрэг, хариуцлага, бодит оролцоо өндөр ач холбогдолтойн дээр зөв төлөвлөлт, удирдлага, манлайлал, бүтээлч үйл ажиллагаагаар өндөр

Та бүхний юу санасан есөн хүсэл бүхэн тань сэтгэлчлэн бүтэх болтугай" хэмээсэн юм.

Ийнхүү Зэвсэгт хүчний тэргүүний анги, салбар, Зэвсэгт хүчний Жанжин штабын оны тэргүүний зохион байгуулалтын бүтцийн нэгжээр шалгарсан хамт олон, оны тэргүүний цэргийн алба хаагчид болон



шагнаж урамшуулах ёслолын ажиллагааг 12 дугаар сарын 30-ны өдөр Офицеруудын ордонд зохион байгуулав.

"Зэвсэгт хүчний тэргүүний анги"-аар дэд хурандаа Х.Золжаргал захирагчтай Зэвсэгт хүчний 331 дүгээр анги, "Зэвсэгт хүчний тэргүүний салбар"-аар хошууч

хүчний 327 дугаар ангийн Зенитийн артиллерийн батареины сум зөөгч-жолооч ахлагч С.Батцэнгэл, "Зэвсэгт хүчний оны тэргүүний ажилтан албан хаагч"-аар Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн туслах аж ахуйн агрономич Г.Мэндбаяр, Зэвсэгт хүчний оны тэргүүний цэргийн гэрээт алба хаагч"-аар Зэвсэгт хүчний 110 дугаар

Энэ үеэр Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга бригадын генерал С.Ганбямба хэлсэн үгэндээ "Зэвсэгт хүчний тэргүүний анги, салбар, офицер, ахлагч, ажилтан, цэргийн гэрээт алба хаагч, Зэвсэгт хүчний Жанжин штабын 2022 оны тэргүүний зохион байгуулалтын бүтцийн нэгж, тэргүүний албан хаагчдаар шалгарсан Та бүхэнд ЗХЖШ-ын даргын зөвлөлийн өмнөөс болон хувиасаа баяр хүргэе. Бид бүхэн хамтдаа 2022 онд Зэвсэгт хүчний өмнө дэвшүүлсэн бодлого, зорилго, зорилтуудаа бүрэн ханган биелүүлсэн бөгөөд өнгөрсөн Баасан гарагт зохион байгуулсан Зэвсэгт хүчний Жанжин штабын тайлангийн хурлын үеэр жилийн



үр дүнд хүрнэ гэдэгт итгэл төгс байна. Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүндээ болон Та бүхний гэр бүлд ажлын их амжилт, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

ажилтнууддаа баяр хүргэж, цаашдын ажил, албанд нь арвин их амжилт, амьдралд нь аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг бэлгэдэн ерөөе.

Хошууч Ц.ПҮРЭВДОРЖ

ЦЭРГИЙН ТАНГАРАГ ДАВТАЖ, ИРЭХ ОНЫ ОНЦЛОХ АЖЛУУДАА ТОДОТГОЛОО



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалынхан Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 111 жил болон 2023 оны шинэ оныг тохиолдуулан 12 дугаар сарын 30-ны энэ өдөр Цэргийн тангараг давтав.

Цэргийн тангараг давтах ёслолын эхэнд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын дарга, хурандаа Д.Дугаррагчаа Хуурай замын цэргийнхний 2022 онд гүйцэтгэсэн ажил, арга хэмжээний талаар мэдээлэл хүргэж, амжилт ололтуудаа дүгнэж, төгсгөлд нь шинэ оны баярын мэндчилгээ дэвшүүллээ.

Мэндчилгээнд "Үндэсний ухамсар, бахархал, үнэт зүйлсээ хадгалан хөгжүүлж, эх оронч үзлээр залуу хойч үеийг

хүмүүжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан үе үеийн ахмадууд болон иргэний үүргээ нөр төртэй биелүүлэн Зэвсэгт хүчинд алба хаасан эрхэм байлдагч, түрүүч, өдгөө алба хааж байгаа генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, ажилтан албан хаагчдаа шинэ оны мэндийг өргөн дэвшүүлж, Та бүхний гэр бүл, үр хүүхдүүдэд эрүүл энх, аз жаргал хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе" гэсэн юм.

Мөн тэрээр Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын 2023 оны зорилго, зорилтыг бүрэн дүүрэн гүйцэтгэхэд алба хаагч бүрийн үүрэг оролцоо, идэвх зүтгэл өндөр байх ёстойг дурдаад хамтын хүчин чармайлтаар шинэлэг сэтгэлгээ, шинэ арга барилаар олон ажлын ард хамтдаа гарна хэмээн онцлолоо.



Сургалт

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №47

ДА ҮСГИЙН БҮТЭЦ, ЗӨВ, ЦЭВЭР БИЧИХ

ДА бол дэвсгэр үсэг. Хатуу дэвсгэрт ордог. Үгийн эхэнд, мөн дунд орох дэвсгэр бус хэлбэр нь өмнө үзсэн ТА үсгийнхтэй яг адил. Монгол хэлний аялгуунуудад сэлгэж хэлдэг ТА, ДА гийгүүлэгчийг монгол бичигт адилхан тэмдэглэдэг. Дунд орох дэвсгэр ДА-г гэдэс, шүд-ээр, адагт дэвсгэрлэснийг нь гэдэс, сүүлээр тэмдэглэнэ. Үгийн төгсгөлд хэлбэрээр дэвсгэрлэдэг эд, дэд гэсэн хоёрхон монгол үг буй.

Уншигч та бүхэн үгийн эхэнд, дунд, төгсгөлд ордог ДА, ДЭ, ДИ, ДО, ДУ, ДӨ, ДҮ гэж аялгуулан дуудаж үе үсэг хэрхэн хувирч буйг нүдлэн тогтоогоорой.

Бичмэл тигээр:

